

БАТЛАВ
"РАДИО ТЕЛЕВИЗИЙН ҮНДЭСНИЙ,
СҮЛЖЭЭ" УЛСЫН ТӨСӨВТ
ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛ



С. ЦАГААНХҮҮ

ХУДАЛДАХ ХУДАЛДАН АВАХ
ГЭРЭЭ



2022.01.18

№ *ХХ/22/05*

Улаанбаатар хот

Нэг талаас "Радио телевизийн үндэсний сүлжээ" УТҮГ-ыг төлөөлж Хангамж үйлчилгээний албаны дарга Э.Энхгэрэл /цаашид "Захиалагч" гэх/, нөгөө талаас "Эерэг эвиденс" ХХК-ийг төлөөлж менежер Я.Болорбилэг /цаашид "Нийлүүлэгч" гэх/ нар /хамтад нь "Талууд" гэх / Монгол Улсын Иргэний Хуулийн 243-261, 343-358 дугаар зүйлүүдийг үндэслэн дараах нөхцлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1 Энэхүү гэрээний зорилго нь Нийлүүлэгч тал нь Захиалагч талд шаардлагатай сэлбэгийг (цаашид "бараа" гэх) нийлүүлэн, түүний өмчлөлд шилжүүлэх, бараанд баталгаат хугацааны туршид гарсан эвдрэл, гэмтлийг үнэ төлбөргүй засварлах, үйлчилгээ үзүүлэх, захиалагч нь барааг тогтоосон хугацаанд хүлээн авч, үнийг төлөх хэлцлийн нөхцөл, Талуудын эрх үүрэг, хүлээх хариуцлага болон эдгээртэй холбоотойгоор үүсэх бусад харилцааг зохицуулахад оршино.

ХОЁР. НИЙЛҮҮЛЭХ БАРААНЫ ҮНЭ

- 2.1 Энэхүү гэрээний нийт үнийн дүн 19 950 000 /арван есөн сая есөн зуун тавин мянга/ төгрөгийг нийлүүлэгч талын Голомт банкны 1415113989 тоот дансанд ажлын 5 хоногт багтаан шилжүүлнэ.

ГУРАВ. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

- 3.1 Нийлүүлэгч тал нь гэрээний 2.1-т заасан төлбөр хийгдсэнээс хойш барааг ажлын 7 хоногт багтаан тоо ширхгийн дагуу нийлүүлнэ.
3.2 Энэхүү гэрээ нь Талуудын бүрэн эрхт төлөөлөгчид гэрээнд гарын үсэг зурж тамга тэмдэг дарсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж энэхүү гэрээний 6.1-т заасан баталгаат хугацааны турш хүчин төгөлдөр байна.

ДӨРӨВ. НИЙЛҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 4.1 Нийлүүлэгч нь дараах үүрэг хүлээнэ.
4.1.1 Захиалагчийн үйл ажиллагааны шаардлагыг хангасан, урьдчилан тохиролцсон загвар, техникийн үзүүлэлт бүхий төхөөрөмж нийлүүлэх;
4.1.2 Барааг энэхүү гэрээний 3.1-т заасан хугацаанд Нийлүүлэгч Захиалагчид хүлээлгэн өгөх бөгөөд хүлээлгэн өгөх үед түүний дагалдах бичиг баримт, тоо ширхэг, иж бүрдлийн талаар үнэн бодит мэдээллийг тусгасан Бараа

- хүлээлгэн өгч, бараа хүлээлцсэн тухай актыг Захиалагчид бичгээр гаргаж өгөх;
- 4.1.3 Нийлүүлэх Бараа нь Монгол Улсад мөрдөгдөж байгаа хууль, тогтоомжид заасан чанарын шаардлага хангасан байх;
 - 4.1.4 Нийлүүлэгч нь холбогдох байгууллагаас тухайн барааг нийлүүлэх тусгай зөвшөөрөл, лицензийг эсвэл үйлдвэрлэгчээс тухайн барааг нийлүүлэх онцгой эрх, зөвшөөрлийг авсан байх;
 - 4.1.5 Нийлүүлсэн Бараа нь чанарын шаардлага хангахгүй эсвэл энэхүү гэрээнд зааснаас өөр эсвэл дутуу бол чанарын шаардлага хангасан тухайн төрлийн доголдолгүй ижил Бараагаар солих, засварлах, гүйцээн нийлүүлэх, эсвэл Захиалагчид үүссэн хохирлыг нөхөн төлөх үүрэг хүлээнэ;
 - 4.1.6 Баталгаат хугацаанаас хойших хугацаанд барааны засвар үйлчилгээний талаар Захиалагчтай хамтран ажиллах, хөнгөлөлттэй нөхцөлөөр үйлчилгээ үзүүлэх;
 - 4.1.7 Барааны ашиглалтын заавар, зураг схем, дагалдах бичиг баримтаар хангах;
- 4.2 Нийлүүлэгч нь дараах эрх эдэлнэ.
- 4.2.1 Захиалагчаас энэхүү гэрээний 2.1-т заасан Барааны үнийг хугацаандаа төлөхийг шаардах;
 - 4.2.2 Захиалагчаас энэхүү гэрээгээр хүлээсэн бусад үүргээ биелүүлэхийг шаардах;
 - 4.2.3 Захиалагч нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр энэхүү гэрээний 2.1-т заасан хугацаанаас хойш хуанлийн 30 хоногийн дотор төлбөр төлөөгүй бол гэрээг нэг талын санаачилгаар цуцлах эрхтэй.

ТАВ. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 5.1 Захиалагч нь дараах үүрэг хүлээнэ.
- 5.1.1 Барааны үнийг энэхүү гэрээний 2.1-д заасан нөхцөлөөр Нийлүүлэгчийн нэхэмжлэлийг үндэслэн шилжүүлэх;
 - 5.1.2 Барааг болон бичиг баримтын хамт энэхүү гэрээнд заасан хугацаанд шуурхай хүлээж авах;
 - 5.1.3 Барааг болон түүний дагалдах бичиг баримт, иж бүрдэл, сав баглаа, боодол, тоо ширхэгийг шалган актаар хүлээн авах;
 - 5.1.4 Энэхүү гэрээгээр хүлээсэн бусад үүргээ биелүүлэх;
- 5.2 Захиалагч нь дараах эрх эдэлнэ.
- 5.2.1 Нийлүүлэгч нь энэхүү гэрээний 3.1-т заасан хугацаанд барааг нийлүүлээгүй, нийлүүлсэн Бараа бүтээгдэхүүн нь Захиалагчийн үйл ажиллагааны шаардлагыг хангахгүй бол гэрээг нэг талын санаачлалаар цуцалж, учирсан хохирлоо нэхэмжлэн авах;
 - 5.2.2 Энэхүү гэрээний 5.1.3-т заасны дагуу Бараа болон гүйцэтгэсэн ажил үйлчилгээг хүлээн авах үед мэдэх боломжгүй буюу энгийн нүдээр харахад мэдэх боломжгүй далд болон бусад доголдлын талаар баталгаат хугацааны туршид мэдэгдэх, энэхүү гэрээний 4.1.5-т заасан доголдлын талаар мэдсэнээс хойш Нийлүүлэгчид хугацаагүй гомдлын шаардлага гаргах, Нийлүүлэгчээс ямар нэг доголдолгүй ижил төрлийн Бараагаар солихыг эсвэл үнэ төлбөргүй засварлаж өгөхийг шаардах;
 - 5.2.3 Энэхүү гэрээгээр хүлээсэн бусад үүргээ биелүүлэхийг Нийлүүлэгчээс шаардах;

ЗУРГАА. БАРААНЫ БАТАЛГААТ ХУГАЦАА

- 6.1 Энэхүү гэрээний дагуу Нийлүүлэгч нь нийлүүлж байгаа бараандаа 12 /арван хоёр/ сарын баталгаа өгч байгаа бөгөөд баталгаат хугацаа нь барааг ашиглалтанд оруулсан өдрөөс эхэлнэ.
- 6.2 Баталгаат засварын хугацаанд тоног төхөөрөмж, тэдгээрийн найдвартай ажиллагааг Нийлүүлэгч тал бүрэн хариуцна. Баталгаат засварын хугацаанд ямар нэг эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд нийлүүлэгч тал өөрийн засвар үйлчилгээний журмын дагуу хурдан, шуурхай чанартай хийж гүйцэтгэнэ. Дараах тохиолдолд, засвар үйлчилгээ хийлгэнэ.
 - 6.2.1 Бараанд үйлдвэрлэлийн гэмтэл гарсан тохиолдолд,
 - 6.2.2 Бараануудын тохиргоонд алдаа гарах,
 - 6.2.3 Гэрээнд заасан хугацаандаа ажиллахгүй байх.
- 6.3 Бараа дараах байдлаар гэмтсэн тохиолдолд баталгаат хугацааны засварт тооцохгүй.

Үүнд:

 - Төвийн эрчим хүчийн хүчдэлийн хэлбэлзэл, түүнээс гарч болох гэмтэл;
 - Байгууллагын ерөнхий самбарын Нейтраль /N-хянах самбар/ хөндийрснөөс болж гарсан гэмтэл;
 - Лац, ломбо оролдсон, хөдөлгөсөн, зөвшөөрөлгүйгээр задалсан;
 - Хэрэглээний буруугаас гаралт талдаа үүсгэсэн богино залгаа, хэт ачааллаас болж төхөөрөмж эвдэрсэн.

ДОЛОО. НУУЦ ХАДГАЛАХ

- 7.1 Нийлүүлэгч нь Гэрээ байгуулсантай холбогдон шууд болон шууд бусаар мэдсэн, олж авсан, Захиалагчтай холбоотой бизнесийн нууцад хамаарах аливаа мэдээ, мэдээлэл, баримтыг Захиалагчийн зөвшөөрөлгүйгээр өөрийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд эсвэл Захиалагчийн эсрэг ашиглахгүй, аливаа гуравдагч этгээдэд амаар болон бичгээр задруулахгүй, дамжуулахгүй байх үүргийг хугацаагүй хүлээнэ.
- 7.2 Нийлүүлэгч нь энэхүү гэрээний 7.1-д заасан нөхцөлийг тал зөрчсөн тохиолдолд үүнтэй холбоотойгоор үүсэх аливаа хохирлыг бүрэн барагдуулна.

НАЙМ. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

- 8.1 Нийлүүлэгч энэхүү гэрээний 4.1.1, 4.1.2, 4.1.3, болон гэрээний Хавсралтад дурдсан техникийн тодорхойлолт, чанарын шаардлагад зааснаас дутуу, чанаргүй, үйлдвэрээс шалтгаалсан гэмтэлтэй бараа нийлүүлсэн тохиолдолд барааг шинээр солих буюу буцаах, уг барааны нийлүүлэгчид шилжүүлсэн мөнгөн төлбөрийг буцаан авах, үүнтэй холбоотой учирсан шууд болон шууд бус хохирлыг шаардах эрхтэй.
- 8.2 Барааны эрхийн доголдлын талаарх аливаа гомдлын шаардлагыг Нийлүүлэгч тал бүрэн хариуцана.
- 8.3 Захиалагч тал энэхүү гэрээгээр тогтоосон хугацааны дотор барааны үнийг төлөхгүй саатуулбал, хугацаа хожимдуулсан хоног тутамд төлбөл зохих үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх хэмжээний алдангийг Нийлүүлэгчид төлнө.
- 8.4 Нийлүүлэгч нь энэ гэрээний 3.1-т заасан хугацаанд Барааг нийлүүлээгүй бол ийнхүү хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гэрээний дүнгийн 0.1 хувьтай тэнцэх хэмжээний алдангийг Захиалагчид төлнө.
- 8.5 Талуудын аль нэг нь энэхүү гэрээний 5.2.1-т заасны дагуу гэрээг нэг талын санаачилгаар цуцлах дохиолдолд буруутай тал нөгөө талдаа Монгол Улсын Иргэний хуулын дагуу зохих хэмжээний торгуулийг төлөх үүрэг хүлээнэ.

- 8.6 Алданги торгууль төлсөн нь Талуудыг үндсэн үүрэг болон учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээс чөлөөлөх үндэслэл болохгүй.
- 8.7 Учирсан хохирол гэдэгт Талууд гэрээний үүргээ биелүүлээгүй улмаас аль нэг талд гуравдагч этгээдээс гаргасан гомдлын шаардлагыг хангахтай холбоотой зардал, өөрт учирсан бодит болон бодит бус хохирлыг ойлгоно.
- 8.8 Энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь биелүүлээгүй Тал нь давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөс бусад тохиолдолд хариуцлагаас чөлөөлөгдөхгүй.

ЕС. НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ, ҮЙЛЧЛЭХ ХУУЛЬ

- 9.1 Энэхүү гэрээнд оруулсан аливаа өөрчлөлт болон нэмэлт нь хоёр Талын эрх бүхий төлөөлөгчид зөвхөн бичгээр үйлдэж гарын үсэг зурсан тохиолдолд хүчин төгөлдөр байна.
- 9.2 Энэхүү гэрээнд шууд заагаагүй аливаа асуудлыг Монгол Улсын дагаж мөрдөж буй хууль тогтоомжоор зохицуулна.

АРВ. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

- 10.1 Холбогдох хууль тогтоомжинд заасан гэнэтийн давагдашгүй хүчин зүйлсийн улмаас Талуудын аль нэг нь гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол нөгөө талдаа ажлын гурав хоногийн дотор бичгээр мэдэгдэх ба энэ тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэхүү нөхцөл байдал үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно.
- 10.2 Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлс бий болсон нь хуанлын нэг сараас дээш хугацаагаар үргэлжилбэл Талууд асуудлыг харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.
- 10.3 Гэнэтийн давагдашгүй хүчин зүйл гэдэгт гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер усны гамшиг зэрэг байгалийн гамшиг, нийтийг хамарсан үймээн, эсэргүүцлийн хөдөлгөөн, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио, цээр зэрэг талуудын хүсэл зоригоос үл хамаарах шалтгаануудыг ойлгоно.

АРВАН НЭГ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 11.1 Энэхүү гэрээтэй холбогдон гарч болзошгүй бүх санал зөрөлдөөн, маргааныг Талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ. Санал зөрөлдөөн, маргааныг зөвшилцөөнөөр шийдвэрлэж чадахгүй тохиолдолд шүүхээр шийдвэрлүүлнэ.

АРВАН ХОЁР. БУСАД ЗҮЙЛ

- 12.1 Талууд энэхүү гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ аль нэг талынхаа албан ёсны зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд хэсэгчилсэн буюу бүрэн хэмжээгээр шилжүүлэх эрхгүй.
- 12.2 Захиалагч болон Нийлүүлэгчийн аль аль нь ажлын уулзалтад оролцохыг нөгөө талаас шаардах эрхтэй. Ажлын уулзалтад үлдэж буй ажлын төлөвлөгөөг хянан үзэж, урьдчилан анхааруулах, гарсан асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ.
- 12.3 Гэрээний гүйцэтгэлийн явцад аль ч тал нэмэлт өөрчлөлт оруулах саналаа нөгөө талдаа бичгээр мэдэгдэж болох ба саналыг хүлээн авсан тал ажлын 3-аас дээшгүй хоногийн дотор нэмэлт өөрчлөлт оруулах эсэх талаар өөрийн саналыг хариу мэдэгдэнэ. Талууд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах хүсэл эрмэлзэлтэй байвал боломжийн хугацаанд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах

- тухай протоколыг бичгээр үйлдэн эрх бүхий хүмүүсээр баталгаажуулна.
Энэхүү протокол нь гэрээний хамт, гэрээтэй нэгэн адил хүчинтэй байна.
- 12.4 Талуудын төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал, үүсгэн байгуулагчид, өмчлөгчид нь өөрчлөгдсөнөөс үл хамааран энэхүү гэрээ үйлчлэх хугацааны туршид хүчин төгөлдөр байна.
- 12.5 Энэхүү гэрээг 2 хувь үйлдэж, тал тус бүр нэг хувийг хадгалах бөгөөд хувь тус бүр хууль зүйн адил хүчинтэй байна.


ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Захиалагч талыг төлөөлж:

Хангамж үйлчилгээний албны дарга

 /Э.Энхгэрэл/

Гэрээний мэргэжилтэн


 /Б.Болормаа/

Утас: 75112020

Хаяг: БГ дүүрэг 17-р хороо
Амарсанаагийн гудамж 18

Нийлүүлэгч талыг төлөөлж:

"Эерэг эвиденс" ХХК-ий менежер

 /Я.Болорбилэг/

Утас: 88137882


Хаяг:


ТӨСӨД
ЭМ АНГААТ ГҮХТ
ТЭЛЭВИЗИЙН
ҮНДЭСНИЙ
ХАНАГАА
УЛСЫН
МОНГОЛ

ХМХА тоот гэрээний хавсралт №1

"Эерэг эвиденс" ХХК-наас худалдан авах багаж сэлбэгийн жагсаалт

№	Барааны нэр	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	7/8 фидер	500	39 900	19 950 000
2				
3				
	Бүгд үнэ			19 950 000

Хянасан:  Э.Энхгэрэл
/ РТҮС УТУГ-ын Хангамж үйлчилгээний
албаны дарга/

 Я.Болорбилэг
/Эерэг эвиденс ХХК-ий менежер/